

“ҮЦТХТ” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
..... / Ш.ЛХАГВА /

“.....” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ ..... /..... /

## Мөнгөн хөрөнгийн гүйлгээ хийх гэрээ / Аж Ахуйн Нэгж /

20... оны ..... -р сарын ..... өдөр

№

аймаг/хот

Энэхүү гэрээг нэг талаас “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК

/цаашид “ҮЦТХТ” гэх/ нөгөө талаас “.....” ҮЦК” ХХК /цаашид ҮЦК гэх/

РД:..... түүнийг төлөөлж ..... ажилтай..... овогтой

....., Аж ахуйн нэгжийн нэр ..... РД..... түүнийг төлөөлж

..... ажилтай ..... овогтой ..... нэр ..... РД.....

ТХДансны дугаар..... нар /цаашид талууд гэх/ “Үнэт цаасны зах зээлийн тухай” хууль, “ Монгол

улсын Иргэний хууль, Хувь хүний нууцын тухай хууль, “ҮЦТХТ” ХХК-ийн “Мөнгөн хөрөнгийн гүйлгээний журам”

/цаашид журам гэх/, үндэслэн дараах нөхцөлтэйгээр харилцан тохиролцож байгуулав.

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү гэрээгээр талуудын эрх үүргийг тогтоох, харилцагчидийн үйлчлүүлэх зардал болон цаг хугацааг хэмнэж түргэн шуурхай үйлчлэх зорилгоор нэг удаагийн гэрээ байгуулж, ҮЦТХТ дэх өөрийн төвлөрсөн хадгаламжийн данснаас зарлагын гүйлгээг өөрийн нэр дээрх арилжааны банкин дахь дансанд шилжүүлгээр авахад үүсэх харилцааг зохицуулна.

1.2 Энэхүү гэрээний хугацаа нэг жил бөгөөд гэрээний хугацаа дуусахад талуудаас гэрээг цуцлах хүсэлт гаргаагүй тохиолдолд гэрээг нэг жилээр сунгагдсанд тооцно.

### Хоёр. Үндсэн нөхцөл

2.1. ҮЦК нь “ҮЦТХТ” ХХК-тай “хамтран ажиллах” гэрээ байгуулсан байх.

2.2. Харилцагч нь “ҮЦТХТ” ХХК-д төвлөрсөн хадгаламжийн данс нээлгэсэн байх

2.3. ҮЦК нь харилцагчийн төвлөрсөн хадгаламжийн данснаас /ТХД/ 20 сая төгрөгөөс дээш дүнтэй зарлагын гүйлгээг хийлгэхдээ “төвлөрсөн хадгаламжаас мөнгө хүсэх өргөдөл” /маягт-1/- ийг бөглөж ирүүлэн гүйлгээг хийлгэх.

2.4. “Мөнгөн хөрөнгийн гүйлгээ хийх гэрээ” байгуулсан харилцагчдын мөнгөн хөрөнгийг ҮЦК-с цахимаар ирүүлсэн жагсаалтыг/маягт-3/ үндэслэж зарлагын гүйлгээ хийх.

2.5. Харилцагч өөрийн нэр дээрх арилжааны банк дах дансны дугаараа доор бичиж, тухайн дансанд ҮЦТХТ-ийн зарлагын гүйлгээг хүлээж авна. Үүнд:

а. ....банкны..... тоот данс /гараар бөглөх/

б. ....банкны.....тоот данс /гараар бөглөх/

2.6. Харилцагч төвлөрсөн хадгаламжаас зарлагын гүйлгээ хийлгэх бүрт ҮЦТХТ-ийн “Мөнгөн хөрөнгийн гүйлгээний журам”-ын 10.4 дахь заалтын дагуу шимтгэл төлнө.

### Гурав. ҮЦТХТ-ийн эрх, үүрэг

3.1. ҮЦТХТ нь дараах эрхтэй:

3.1.1. Харилцагчийн ТХД-наас зарлагын гүйлгээг хийхдээ компанийн журам, гэрээний 4.2-д заасан мэдээлэл зөрсөн бол мөнгөн хөрөнгийн зарлагын гүйлгээг хийхээс татгалзах;

3.1.2. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг талуудаас шаардах

3.1.3. ҮЦТХТ-д хууль, дүрэм журамаар олгогдсон бусад эрх

3.2. ҮЦТХТ нь дараах үүрэг хүлээнэ:

3.2.1. ҮЦТХТ -н Мөнгөн хөрөнгийн гүйлгээний журмыг баримтлан ажиллах;

3.2.2. Мөнгөн хөрөнгийн зарлагын гүйлгээг түргэн шуурхай, үнэн зөв хийх; 3.2.3. Харилцагчийн харилцах данс болон гүйлгээний талаарх мэдээллийг хуульд зааснаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй байх, нууцлалыг хадгалах;

3.2.4. Өөрийн үйлчилгээ, шимтгэлтэй холбоотой журамд өөрчлөлт орсон тохиолдолд харилцагчдад ажлын 2 хоногт багтаан өөрийн цахим хуудсаар дамжуулан мэдээлэх.

3.2.5. ҮЦТХТ нь харилцагчийн дараах утасны дугаараар мэдээлэл хүргэнэ.

### Дөрөв. ҮЦК-ийн эрх, үүрэг

4.1. ҮЦК нь дараах эрх эдлэнэ:

4.1.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг талуудаас шаардах;

4.1.2. Харилцагчийн төвлөрсөн хадгаламжийн дансны боломжит үлдэгдэл нь хүрэлцэхгүй тохиолдолд “төвлөрсөн хадгаламжаас мөнгө хүсэх өргөдөл”-ийг хүлээн авахгүй байх;

4.2. ҮЦК нь дараах үүргийг хүлээнэ:

- 4.2.1. Харилцагчдынхаа мөнгөн хөрөнгийн гүйлгээний талаарх мэдээллийг хуульд зааснаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй байх, нууцлалыг хадгалах;
- 4.2.2. Харилцагчийн өгсөн хүсэлтийн дагуу төвлөрсөн хадгаламжаас мөнгө хүсэх өргөдлийг үнэн зөв бөглөж баталгаажуулан ҮЦТХТ-д хүргүүлэн гүйлгээ хийлгэх;
- 4.2.3. Харилцагч нартаа хөрөнгийн зах зээлийн талаарх мэдээ мэдээлэл, мөнгөн хөрөнгийн гүйлгээ хийх боломжуудыг цаг тухай бүрт нь мэдээлэн танилцуулах;
- 4.2.4. ҮЦТХТ ХХК-тай жилийн эцэст өөрийн харилцагчдын мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн тооцоо нийлсэн акт үйлдэх;
- 4.2.5. Мөнгөн хөрөнгийн гүйлгээний журмын заалтуудыг хэрэгжүүлж ажиллах ба өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас харилцагчид учирсан хохирлыг бүрэн хариуцна.

**Тав. Аж ахуйн нэгжийн эрх, үүрэг**

5.1. Аж ахуйн нэгж нь дараах эрх эдэлнэ:

- 5.1.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг талуудаас шаардах;
- 5.1.2. Гэрээ байгуулсан эрх бүхий албан тушаалтан бичгээр хүсэлт гаргаж, тамга тэмдэгээр баталгаажуулсан баримтыг үндэслэн уг гэрээг цуцлах;
- 5.1.3. Интернет эрх авч өөрийн дансны хуулгыг харах, мэдээлэл авах, шинжилгээ хийх.

5.2. Аж ахуйн нэгж нь дараах үүрэг хүлээнэ:

- 5.2.1. Харилцагч нь өөрийн мэдээлэлд өөрчлөлт орсон тухай бүр талуудад мэдэгдэж гэрээг шинэчлэн байгуулна.
- 5.2.2. Харилцагч нь гэрээнд өөрийн мэдээллийг үнэн зөв, гаргацтай алдаагүй бичнэ.
- 5.2.3. Харилцагч нь гэрээний биелэлтийг тухай бүр шалгаж байх.

**Зургаа. Хариуцлага**

- 6.1. Гэрээ цуцлагдахаас өмнө ҮЦК-иар дамжуулан ирүүлсэн мөнгө хүсэх өргөдлийн эрх үүрэг нь биелэгдэж дуусах хүртэл хугацаанд гэрээний зохицуулалт талуудын хувьд хүчин төгөлдөр мөрдөгдөнө.
- 6.2. ҮЦК-иас ирүүлсэн төвлөрсөн хадгаламжийн данснаас мөнгө хүсэх өргөдлийн бүрдэл болон бүрдлийн үнэн зөвийг ҮЦК бүрэн хариуцах бөгөөд уг гэрээний 4.2.1, 4.2.2 дэх заалтыг хэрэгжүүлээгүйн улмаас үүсэх аливаа хариуцлагыг ҮЦТХТ хүлээхгүй.

**Долоо. Бусад**

- 7.1. ҮЦК нь нэгдэх, нийлэх, хуваах, тусгаарлах зэргээр зохион байгуулалтын хэлбэрээ өөрчилж буй тохиолдолд ажлын 3 хоногийн өмнө ҮЦТХТ-д урьдчилан бичгээр мэдэгдэх бөгөөд шинээр бий болж байгаа хууль ёсны эрх залгамжлагчтай гэрээ байгуултал, уг нөхцөл байдлын үүднээс харилцагч гэрээг цуцлах санал тавих хүртэл гэрээг хүчинтэйд тооцно.
- 7.2. Аль нэг талын бичгээр ирүүлсэн хүсэлтээр талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээний нөхцөлд өөрчлөлт оруулж болно. Ийнхүү шийдвэрлэсэн нэмэлт, өөрчлөлт нь энэхүү гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд гэрээний салшгүй хэсэг байна.
- 7.3. Энэхүү гэрээг хэрэгжүүлэх явцад гарах аливаа маргааныг талууд харилцан тохиролцоо замаар шийдвэрлэх ба тохиролцоонд эс хүрвэл талууд холбогдох хууль тогтоомжийн дагуу Монгол Улсын Шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 7.4. Энэхүү гэрээнд талуудын гарын үсэг зурсанаар хүчин төгөлдөр болно.
- 7.5. Гэрээг Монгол хэл дээр 3 /гурав/ хувь үйлдэх бөгөөд хувь тус бүр адил хүчинтэй байна.

**Гэрээ байгуулсан:**

“Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ХХК-ийг төлөөлж гүйлгээний нягтлан бодогч  
Овог: \_\_\_\_\_  
Нэр: \_\_\_\_\_  
\_\_\_\_\_/гарын үсэг/  
Утас: \_\_\_\_\_  
Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг 4-р хороо Самбуугийн гудамж 16-1

Аж ахуйн нэгжийг төлөөлж  
Албан тушаал: \_\_\_\_\_  
Овог: \_\_\_\_\_  
Нэр: \_\_\_\_\_  
\_\_\_\_\_/гарын үсэг/  
Тэмдэг  
Утас: \_\_\_\_\_  
Хаяг: \_\_\_\_\_

“ \_\_\_\_\_ ” ҮЦК ХХК-г төлөөлж:  
\_\_\_\_\_ ажилтай  
Овог: \_\_\_\_\_  
Нэр: \_\_\_\_\_  
\_\_\_\_\_/Гарын үсэг/  
Утас: \_\_\_\_\_  
Хаяг: \_\_\_\_\_